



ПРЕМИУМ НЭКСУС ХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2026 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

ТУЗ-ийн гишүүнийг чөлөөлөх,  
шинээр түр томилох, ТУЗ-ийн хороодын  
бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.5 дахь заалт, Премиум Нэксус ХК ("Компани")-ийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо болон Цалин урамшууллын хорооны зөвлөмжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. ТУЗ-ийн гишүүн Г.Бат-Эрдэнэ-г 2026 оны 06-р сарын 30-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.
2. ТУЗ-ийн гишүүний нөхөн сонгууль хүртэлх хугацаанд Н.Энхболдыг 2026 оны 06-р сарын 30-ны өдрөөс ТУЗ-ийн гишүүнээр түр томилж, ТУЗ-ийн гишүүнээр ажиллах хугацаанд цалин урамшуулал олгохгүй байхаар шийдвэрлэсүгэй.
3. ТУЗ-ийн Аудитын хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр баталсугай. Үүнд:
  - (i) В.Ганзориг (дарга),
  - (ii) Гари Биондо,
  - (iii) А.Ганхуяг.
4. ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр баталсугай. Үүнд:
  - (i) В.Ганзориг (дарга),
  - (ii) Н.Энболд,
  - (iii) Гари Биондо.
5. ТУЗ-ийн Цалин урамшууллын хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр баталсугай. Үүнд:
  - (i) Ө.Эрдэнэчимэг (дарга),
  - (ii) А.Ганболд,
  - (iii) Гари Биондо.
6. ТУЗ-ийн БОНЗ хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр баталсугай. Үүнд:
  - (i) Ө.Эрдэнэчимэг (дарга),
  - (ii) Гари Биондо,
  - (iii) Ч.Мөнхчимэг.
7. ТУЗ-ийн гишүүн, ТУЗ-ийн хороодын бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийг холбогдох зохицуулагч байгууллагуудад мэдээлэхийг Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-д даалгасугай.

(Гарын үсгийн хуудас дагалдана.)

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХАРААТ БУС ДАРГА:



ГАРИ БИОНДО

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:

А.ГАНХУЯГ

А.ГАНБОЛД

Н.ЭНХБОЛД

Ч.МӨНХЧИМЭГ

Г.ЧИНЗОРИГ

Б.БАТ-ЭРДЭНЭ

Ө.ЭРДЭНЭЧИМЭГ

В.ГАНЗОРИГ